



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын Г  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Блю скай ХХК-ны "Блю скай тауэр" зочид буудлын 16/027, Таштвер ХХК-ны "Лионс" зочид буудлын 15/024, Гоби камел хейрд ХХК-ны "Гоби камел хейрд" дэн буудлын 15/052, Ган энх ХХК-ны "Гурван баян" дэн буудлын 13/250, Монголийн вояж-ны ХХК "Мөнхтэнгэр-2" жуулчны баазын 15/033 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

1150500151

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batsoy* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 05 сарын 01  
өдрийн 13 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.05.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Блю Скай ХХК	5093171	Блю скай тауэр	СБД-ийн 1-р хороо ЭТӨЧ-17
2	Таштвер ХХК	5060567	Лионс	БЗД-ийн 6-р хороо ЭТӨЧ-31/2а

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 05 сарын 01  
өдрийн А35 дугаар тушаалын  
хоёрдугаар хэсрэлт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.05.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Цацрах мөр ХХК	5442699	Санпат-Монгол	ЧД-ийн 4-р хороо 37-49
2	Хавай жим ХХК	5739535	Хавай	БЗД-ийн 25-р хороо Олзвойн 58а
3	Гоби камел хейрд ХХК	5917328	Гоби камел хейрд	СБД-ийн 3-р хороо Циркийн баруун талын 146-16
4	Ган-энх ХХК	2650452	Гурван баян	СХД-ийн 18-р хороо Москвагийн 18

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 05 сарын 01  
өдрийн А.38 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.05.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монголийн вояж ХХК	2581418	Мөнхтэнгэр-2	ХУД-ийн 8-р хороо, Богд хан уулын тайны амны баруун дэнж

-ooOoo-